

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
2010 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2010.09.01

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,  
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

2009 оны жилийн эцсээр нийт 177 ББСБ тайлангийн нэгтгэлд хамрагдаж байсан бол 2010 оны санхүүгийн тайлант хугацааны эхний хагас жилд нийт 16 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 5 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 188 ББСБ-ын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдлаа.

2010 оны хоёрдугаар улирлын байдлаарх ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

/Хүснэгт 1/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны II улирал	2009 оны II улирал	Өсөлт /+/, бууралт -/
1	ББСБ-ын тоо	188	173	15
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	590	548	42
3	Ажиллагсадын тоо	870	730	140
4	Салбар нэгжийн тоо	60	58	2
5	Харилцагчдын тоо /мянган төгрөгөөр/	76.3	48.9	27.4
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	115,539,684.7	85,291,455.3	30,248,229.4
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>2.34</b>	<b>2.18</b>	<b>0.16</b>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	67,754,807.0	48,085,208.8	19,669,598.2
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>2.38</b>	<b>1.88</b>	<b>0.50</b>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	85,749,294.0	65,734,186.0	20,015,108.0
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>30.16</b>	<b>20.33</b>	<b>9.84</b>
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	77,179,517.4	58,857,930.6	18,321,586.8
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>28.18</b>	<b>26.96</b>	<b>1.22</b>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	8,290,125.9	3,528,570.5	4,761,555.4
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	13,516,457.4	13,379,966.3	136,491.1
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	10,454,217.3	10,879,555.5	-425,338.2
13	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	3,062,240.2	2,500,410.8	561,829.4
1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	11	9	2
	<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>	<b>5.85</b>	<b>4.79</b>	<b>1</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	18,125,991.5	11,761,259.4	6,364,732.1
	<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>	<b>15.69</b>	<b>13.79</b>	<b>1.90</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	13,542,246.4	8,530,907.8	5,011,338.6
	<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>	<b>19.99</b>	<b>17.74</b>	<b>2.25</b>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,633,018.4	6,416,347.0	1,216,671
	<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>	<b>8.90</b>	<b>9.76</b>	<b>-0.86</b>

Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	8,267,792.5	6,921,032.5	1,346,760.0
<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>		<b>10.71</b>	<b>11.76</b>	<b>-1.05</b>
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	27	26	1
<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>		<b>14.36</b>	<b>15.00</b>	<b>-0.64</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	3,559,106.9	2,668,155.7	890,951
<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>		<b>3.08</b>	<b>3.13</b>	<b>-0.05</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	4,440,612.0	1,600,288.9	2,840,323.1
<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>		<b>6.55</b>	<b>3.33</b>	<b>3.23</b>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	3,381,867.1	1,793,485.6	1,588,381.5
<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>		<b>3.94</b>	<b>2.73</b>	<b>1.22</b>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	3,301,937.59	1,480,831.4	1,821,106.2
<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>		<b>4.28</b>	<b>2.52</b>	<b>1.76</b>
3	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	49	44	5
<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>		<b>26.06</b>	<b>23.40</b>	<b>2.66</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	5,766,366.51	5,398,407.8	367,958.7
<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>		<b>4.99</b>	<b>6.33</b>	<b>-1.34</b>
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	5,747,582.62	5,338,119.0	409,463.6
<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>		<b>6.70</b>	<b>8.12</b>	<b>-1.42</b>
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	5,029,422.43	5,207,356.4	-177,934.0
<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>		<b>6.52</b>	<b>8.85</b>	<b>-2.33</b>

**Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:**

2010 оны эхний хагас жилийн байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 11 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 5.8 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 15.7 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 20.0 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн 8.9 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 10.7 хувийг тус тус эзэлж байна. Тэдгээрийг гадаадын хөрөнгө оруулагчдын харьяаллаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 6, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 1, Итали улсын хөрөнгө оруулалттай 1, АНУ-ын хөрөнгө оруулалттай 1, ОХУ-ын хөрөнгө оруулалттай 1 ББСБ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

**Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:**

2010 оны 2 дугаар улирлын байдлаар орон нутагт 27 ББСБ /1 дүгээр улирлын байдлаар 28 байсан ба 2 дугаар улиралд Улаанбаатар Сэлэнгэ ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон/ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 14.4 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 3.1 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 6.5 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 3.9 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.3 хувийг тус тус эзэлж байна.

**Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:**

Хорооны 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 28 дугаар тогтоол батлагдсанаар валют солих цэгийн үйл ажиллагаа эрхэлж байсан, цаашид эрхлэх хүсэлтэй аливаа этгээд нь банк бус санхүүгийн гадаад валютын арилжааг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх эрх зүйн үндэс бүрэлдсэн.

2010 оны 2 дугаар улирлын байдлаар гадаад валютын арилжааг дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 46 ББСБ, зээл, гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөлтэй 3 ББСБ буюу нийт 49 ББСБ зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 26.1 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 5.0 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 6.7 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 6.5 хувийг тус тус эзэлж байна.

ББСБ-уудын тусгай зөвшөөрөл авсан үйл ажиллагаагаар ангилвал дараах байдалтай байна:

/Хүснэгт 2/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо /улирлаар/	
		2010 оны II улирал	2009 оны II улирал
1	Зээл	140	130
2	Факторингийн үйлчилгээ	6	5
3	Төлбөрийн баталгаа гаргах	6	5
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	7
6	Гадаад валютын арилжаа	110	99
7	Итгэлцлийн үйлчилгээ	9	12
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	8	8
10	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ	1	0

2010 оны эхний хагас жилд 1 ББСБ-ын зээл, 2 ББСБ-ын гадаад валютын арилжаа, 3 ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 2 ББСБ-д гадаад валютын арилжаа, 1 ББСБ-д зээл, 1 ББСБ-д итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгож, 16 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн бол 3 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг сэргээсэн байна.

ББСБ-уудын олгож буй зээлийн хүүгийн болон татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрт төлж буй хүүгийн түвшин:

/Хүснэгт 3/

№	Үзүүлэлт	Хүүгийн хувь	
		Тайлант улирлаар	Өмнөх оны мөн үеэр
1	Дээд хүү /зээл, активын/	4.8	4.5
	Доод хүү /зээл, активын/	2.5	3.0
2	Дээд хүү /бусдаас татсан эх үүсвэрийн/	0.4	2.0
	Доод хүү /бусдаас татсан эх үүсвэрийн/	0.2	0.5

2010 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд 10 ББСБ буюу нийт ББСБ-ын 5.3 хувь /1 дүгээр улиралд 13 ББСБ буюу нийт ББСБ-ын 7.1 хувийг эзэлж байсан/ нь эхлэлтийн санхүүгийн тайлангаар, 18 ББСБ буюу нийт ББСБ-ын 9.6 хувь /1 дүгээр

улралд мөн 13 ББСБ буюу нийт ББСБ-ын 7.1 хувийг эзэлж байсан/ нь өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр тус тус хамрагдлаа.

## ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 Активын бүтэц, өөрчлөлт:

ББСБ-уудын тайлант хугацааны нийт активын хэмжээ, бүтцийг өмнөх онтой харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 4/

№	ХӨРӨНГӨ	2010.06.30		2009.06.30		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
<b>А</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>110,793,997.5</b>	<b>95.9%</b>	<b>81,177,671.1</b>	<b>95.2%</b>	<b>29,616,326.4</b>	<b>26.7%</b>
1	Мөнгөн хөрөнгө	35,949,875.9	31.1%	27,179,657.1	31.9%	8,770,218.8	24.4%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	1,925,390.2	1.7%	2,962,659.0	3.5%	-1,037,268.8	-53.9%
3	Нийт зээл	67,754,807.0	58.6%	48,085,208.8	56.4%	19,669,598.2	29.0%
	(Зээлийн эрсдлийн сан)	3,855,103.4	3.3%	2,905,737.9	3.4%	949,365.5	24.6%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	1,383,549.5	1.2%	503.2	0.0%	1,383,046.3	100.0%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0%	503.2	0.0%	-503.2	-
5	Нийт факторингийн тооцооны авлага	134,819.9	0.1%	350.0	0.0%	134,119.9	99.7%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	350.0	0.0%	350.0	0.0%	0.0	0.0%
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	463,570.5	0.4%	180,271.4	0.2%	283,299.0	61.1%
7	Бусад хөрөнгө	7,037,438.0	6.1%	5,675,612.6	6.7%	1,361,825.4	19.4%
<b>Б</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>4,745,687.1</b>	<b>4.1%</b>	<b>4,113,784.2</b>	<b>4.8%</b>	<b>631,902.9</b>	<b>13.3%</b>
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	4,745,687.1	4.1%	4,113,784.2	4.8%	631,902.9	13.3%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>115,539,684.7</b>	<b>100.0%</b>	<b>85,291,455.3</b>	<b>100.0%</b>	<b>30,248,229.4</b>	<b>26.2%</b>

2010 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд нийт актив өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өссөн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмч 23.3 хувь /үүнээс: хоёрдогч өглөг 54.7 хувь/, өр төлбөр 35.9 хувь /үүнээс: итгэлцлийн үйлчилгээний өглөг 57.4, банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 36.4 хувь/ өссөнтэй шууд холбоотой бол зээлийн үлдэгдэл нь нийт активын 58.6 хувь /цэврээр 55.3 хувь/, мөнгөн хөрөнгө 31.1 хувийг буюу нийт 89.7 хувийг эзэлж байгаа нь ББСБ-уудын үндсэн эрхэлж буй үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа зонхилж байгаа нь хэвээрээ байгааг илтгэж байна.

Нийт хөрөнгө оруулалтын 99,7 хувь болох 1,918,879.2 мянган төгрөг нь Эн ви си ББСБ-ын тайлан тэнцэлд бүртгэгдсэн бөгөөд энэ нь тус ББСБ-д Хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас

хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг үндэслэн олгосон зөвшөөрлийн дагуу хийгдсэн 1,846,275.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт болон тус ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 72,604.0 мянган төгрөг байна.

## **2.2 Зээлийн багцын чанар:**

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 5/

№	Ангилал	2010.06.30		2009.06.30		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
1	Хэвийн зээл	59,799,535.1	88.3%	41,173,168.4	85.6%	18,626,366.7	31.1%
2	Хугацаа хэтэрсэн зээл	2,866,070.1	4.2%	2,475,692.5	5.1%	390,377.6	13.6%
3	Чанаргүй зээл. Үүнээс:	5,089,201.8	7.5%	4,436,348.0	9.2%	652,853.9	12.8%
<b>Нийт</b>		<b>67,754,807.0</b>	<b>100.0%</b>	<b>48,085,208.8</b>	<b>100.0%</b>	<b>19,669,598.2</b>	<b>29.0%</b>

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багцад эзлэх хэвийн зээл 2.7 хувиар өссөн, хугацаа хэтэрсэн зээл 0.9 хувиар, чанаргүй зээл 1.7 хувиар тус тус буурсан ба чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 12.8 хувиар өссөн нь олгосон зээлийн эргэн төлөлт, чанар муудаж байгаатай холбоотой байна.

## **ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ**

ББСБ-уудын 2010 оны эхний хагас жилийн тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал дараах байдалтай байна.

/Хүснэгт 6/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2010.06.30		2009.06.30		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
<b>A</b>	<b>Өр төлбөр</b>	<b>25,458,260.2</b>	<b>22.0%</b>	<b>16,330,065.2</b>	<b>19.1%</b>	<b>9,128,195.0</b>	<b>35.9%</b>
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	5,406,108.2	4.7%	3,528,570.5	4.1%	4,761,555.5	57.4%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	15,431,118.6	13.4%	7,984,429.2	9.4%	4,562,671.6	36.4%
3	Бусад эх үүсвэр	599,714.5	0.5%	1,710,229.8	2.0%	-1,110,515.4	-185.2%
	<i>Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр</i>	<i>1,059.3</i>	<i>0.0%</i>	<i>1,241.8</i>	<i>0.0%</i>	<i>-182.5</i>	<i>-17.2%</i>
	<i>Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг</i>	<i>591,299.2</i>	<i>0.5%</i>	<i>1,429,400.9</i>	<i>1.7%</i>	<i>-838,101.7</i>	<i>-141.7%</i>
	<i>Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг</i>	<i>3,656.6</i>	<i>0.0%</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>	<i>3,656.6</i>	<i>0.0%</i>
	<i>Факторингийн үйлчилгээний өглөг</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>	<i>0.0</i>	<i>0.0%</i>
	<i>Гадаад валютын арилжааны эх үүсвэр</i>	<i>3,699.4</i>	<i>0.0%</i>	<i>279,587.1</i>	<i>0.3%</i>	<i>-275,887.7</i>	<i>7457.7%</i>
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	296,000.0	0.3%	0.0	0.0%	296,000.0	0.0%
5	Төслийн зээлийн санхүүжилт	3,725,319.0	3.2%	3,106,835.7	3.6%	618,483.3	16.6%
	<b>Бусад өр төлбөр</b>	<b>4,332,130.5</b>	<b>3.7%</b>	<b>3,227,204.1</b>	<b>3.8%</b>	<b>1,104,926.4</b>	<b>25.5%</b>
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	685,000.3	0.6%	265,064.3	0.3%	419,936.0	61.3%
7	Бусад пассив	3,647,130.2	3.2%	2,962,139.8	3.5%	684,990.4	18.8%

8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>29,790,390.7</b>	<b>25.8%</b>	<b>19,557,269.3</b>	<b>22.9%</b>	<b>10,233,121.4</b>	<b>34.4%</b>
<b>Б</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>85,749,294.0</b>	<b>74.2%</b>	<b>65,734,186.0</b>	<b>77.1%</b>	<b>20,015,108.0</b>	<b>23.3%</b>
9	Хувьцаат капитал	77,179,517.4	66.8%	58,857,930.6	69.0%	18,321,586.8	23.7%
10	Бусад өмч	600,414.6	0.5%	556,987.5	0.7%	43,427.1	7.2%
11	Сангууд	1,136,670.8	1.0%	1,137,562.4	1.3%	-891.6	-0.1%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	5,954,328.8	5.2%	4,783,571.7	5.6%	1,170,757.1	19.7%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	878,362.5	0.8%	398,133.9	0.5%	480,228.6	54.7%
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>115,539,684.7</b>	<b>100.0%</b>	<b>85,291,455.3</b>	<b>100.0%</b>	<b>30,248,229.4</b>	<b>26.2%</b>

Тайлант хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 34.4 хувь, эзэмшигчдийн өмч 23.3 хувиар тус тус өссөн бөгөөд 2009 оны 2 дугаар улиралд нийт пассивын 22.9 хувийг нийт өр төлбөр, 77.1 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2010 оны 2 дугаар улирлын байдлаар нийт пассивт эзлэх өр төлбөр 25.8 хувь, эзэмшигчийн өмч 74.2 хувь болж өөрчлөгдсөн байна. Нийт пассивт эзлэх нийт өр төлбөр буурсан гол шалтгаан нь ББСБ-уудын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн нийт нийт пассивт эзлэх хувь хувь хэмжээ буурсан, нөгөөтэйгүүр дүрмийн сангийн хэмжээ 23.7 хувиар өссөнтэй шууд холбоотой. 878,362.5 мянган төгрөгийн 2-догч өглөг нь нэр бүхий 6 ББСБ-д бүртгэлтэй байна.

### ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2010 оны 2 дугаар улирлын байдлаарх нийт орлого өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар өссөн ба дараах бүтэцтэй байна.

/Хүснэгт 7/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.06.30		2009.06.30		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	9,613,120.9	71.1%	6,855,222.8	51.2%	2,757,898.1	40.2%
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	9,045,146.4	66.9%	6,569,576.2	49.1%	2,475,570.2	37.7%
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	390,822.4	2.9%	210,605.2	1.6%	180,217.2	85.6%
	Үнэт цаасны хүүгийн орлого	28,574.2	0.2%	2,070.9	0.0%	26,503.3	1279.8%
	Бусад хүүгийн орлого	148,577.8	1.1%	72,970.4	0.5%	75,607.4	103.6%
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	3,693,814.8	27.3%	6,292,710.5	47.0%	-2,598,895.7	-41.3%
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	201,537.6	1.5%	224,292.8	1.7%	-22,755.2	-10.1%
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	7,984.2	0.1%	7,740.2	0.1%	244.0	3.2%
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>13,516,457.4</b>	<b>100.0%</b>	<b>13,379,966.3</b>	<b>100.0%</b>	<b>136,491.2</b>	<b>1.0%</b>

Нийт орлого өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар өссөн байх боловч нийт активын өсөлттэй харьцуулахад бууралттай байна.

Нийт орлогод эзлэх нийт хүүгийн орлогын хувь хэмжээ 40.2 хувиар өсөхөд хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, үнэт цаасны хүүгийн орлого голлох нөлөөг үзүүлсэн. Хугацаандаа байгаа хүүгийн орлого ийнхүү өссөн нь ББСБ-уудын олгосон зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 29.0 хувиар өссөн, нөгөөтэйгүүр, зээлийн хүүгийн төлөлт харьцангуйгаар сайжирсантай холбоотой.

Харин хүүгийн бус орлогын үзүүлэлтүүд дараах байдалтай байна:

/Хүснэгт 8/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.06.30		2009.06.30		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
1	Арилжааны орлого	932,997.1	25.3	2,378,334.6	37.8	-1,445,337.5	-60.8
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	1,980,893.0	53.6	3,351,173.8	53.3	-1,370,280.8	-40.9
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	779,924.7	21.1	563,202.0	9.0	216,722.6	38.5
4	Бусад	186,775.7	5.1	152,570.0	2.4	34,205.7	22.4
	<b>НИЙТ</b>	<b>3,693,814.8</b>	<b>100.0</b>	<b>6,292,710.5</b>	<b>100.0</b>	<b>-2,598,895.7</b>	<b>-41.3</b>

Хүүгийн бус орлого нь өнгөрсөн оны мөн үеэс 41.3 хувь буюу нийт орлогын багцад эзлэх хувь хэмжээний хувьд 19.7 хувиар буурсан нь гадаад валютын арилжааны орлого өмнөх оны мөн үеэс 60.8 хувиар, гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого 40.9 хувиар тус тус буурсантай шууд холбоотой байна.

Тайлант хугацааны нийт зардлын бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 9/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.06.30		2009.06.30		Өөрчлөлт	
		мян. төг	хувь	мян. төг	хувь	мян. төг	хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	1,064,322.8	10.2%	830,510.4	7.6%	233,812.4	28.2%
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	7,685,591.9	73.5%	8,301,072.2	76.3%	-615,480.3	-7.4%
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	1,101,740.3	10.5%	1,302,073.0	12.0%	-200,332.7	-15.4%
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	165,560.9	1.6%	119,617.4	1.1%	45,943.4	38.4%
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	27,530.9	0.3%	6,586.1	0.1%	20,944.9	318.0%
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	409,470.4	3.9%	319,696.3	2.9%	89,774.1	28.1%
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>10,454,217.3</b>	<b>100.0%</b>	<b>10,879,555.5</b>	<b>100.0%</b>	<b>-425,338.2</b>	<b>-3.9%</b>

Хэдийгээр нийт орлого өмнөх оны мөн үеэс төдийлэн өсөөгүй /1.0 хувийн өсөлттэй/ ч нийт зардлын хувьд 3.9 хувь буурсан нь эерэг үзүүлэлт юм.

Нийт зардлын бууралтад хүүгийн бус зардал буюу банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал, зээлийн болзошгүй эрсдэлийн зардлын бууралтууд нөлөөлсөн байна.

Зээлийн болзошгүй эрсдэлийн зардлын нийт зардалд эзлэх хувь хэмжээ буурсан нь нэг талаас, өмнөх тайлант үеүдэд бүртгэлтэй байсан хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлүүд эргэн төлөгдсөн, нөгөөтэйгүүр, шинээр олгосон зээлүүдийн чанар сайжирсныг илтгэж буй үзүүлэлт юм.

### ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын 2010 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2008 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

- өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт (1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 107.9 хувь, (2) өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 109.6 хувь, (3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 73.1 хувь;

- төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 202.1 хувь;

- гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 7.4 хувь;

- итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 7.0 хувь;
- үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 2.0 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 459/207 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2009 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 125/50 дугаар хамтарсан тушаалаар баталсан өөрчлөлтийн дагуу активын эрсдэлийн санг 4,116,014.1 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 56,090.9 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байна.

## ЗУРГАА. ДҮГНЭЛТ

ББСБ-ын салбарын нийт актив нь банкны салбарын нийт активын 2.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өссөн бол нийт эзэмшигчдийн өмчийн хувьд банкны салбарын эзэмшигчдийн өмчийн 30.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Харин дүрмийн сангийн хувьд банкны салбарын нийт дүрмийн сангийн 28.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар нэмэгдсэн байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын эзэмшигчдийн өмч, дүрмийн сан, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын актив, валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын эзэмшигчдийн өмч, дүрмийн сангийн хэмжээний нийт ББСБ-уудын холбогдох үзүүлэлтүүдэд эзлэх хувь хэмжээ буурсан хэдий ч тоон үзүүлэлтүүдийн хувьд бүгд өсөлттэй байна.

Мөн салбарын нийт зардал өмнөх оны мөн үеэс 425,338.2 мянган төгрөг /3.91 хувь/-өөр буурсан байна. Ийнхүү зардлын хэмжээ өмнөх оны мөн үеэс буурч, активын хэмжээ өссөн нь салбарын хувьд эерэг үзүүлэлт юм.

2010 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд нийт актив өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өссөн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмч 23.3 хувь, өр төлбөр 35.9 хувь өссөнтэй шууд холбоотой бол зээлийн үлдэгдэл нь нийт активын 58.6 хувь, мөнгөн хөрөнгө 31.1 хувийг буюу нийт 89.7 хувийг эзэлж байгаа нь ББСБ-уудын үндсэн эрхэлж буй үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа зонхилж байгаа нь хэвээрээ байгаа бөгөөд, өмнөх тайлант улирлуудын нэгэн адил мөн л бусад санхүүгийн үйл ажиллагаа, үйлчилгээг төдийлэн эрхлэхгүй байгаатай тус тус холбоотой.

Харин өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 34.4 хувь, эзэмшигчдийн өмч 23.3 хувиар тус тус өссөн бөгөөд 2009 оны 2 дугаар улиралд нийт пассивын 22.9 хувийг нийт өр төлбөр, 77.1 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2010 оны 2 дугаар улирлын байдлаар нийт пассивт эзлэх өр төлбөр 25.8 хувь, эзэмшигчийн өмч 74.2 хувь болж өөрчлөгдсөн байна. Нийт пассивт эзлэх нийт өр төлбөр буурсан гол шалтгаан нь ББСБ-уудын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн нийт нийт пассивт эзлэх хувь хувь хэмжээ буурсантай шууд холбоотой.

Хэдийгээр 2010 оны эхний хагас жилийн тайлант хугацааны нийт орлогод өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлт ороогүй хэдий ч 3,062,240.2 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22.5 хувийн өсөлттэй /2009 оны 2 дугаар улирлын тайлант хугацааны цэвэр ашиг 2,500,410.8 мянган төгрөг/ байна.

Нийт 188 ББСБ-аас 128 ББСБ буюу нийт ББСБ-ын 68.1 хувь нь 3,601,431.3 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан бол 47 ББСБ буюу нийт ББСБ-ын 25.0 хувь нь 539,191.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Хорооны 2008 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам”-ын дагуу ББСБ-ын үйл *ББСБ-уудын 2010 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга*



ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээрх шалгалтын дүнгээр санхүүгийн тайлан тэнцэлд үндэслэн холбогдох үзүүлэлтүүдийг тооцож бодитой үнэлгээ, дүгнэлт өгөхтэй холбогдуулан нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 1,000,000.0 мянган төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай, 400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай болон зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ гэсэн 4 бүлэгт хуваалаа.

## **САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**